



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2019 / 9





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Статистикийн мэдээллийг хэрхэн авах вэ?

WWW.GOVI-ALTAI.NSO.MN

web

WWW.1212.MN

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



ezStat

Ухаалаг гар утас, таблет ашиглан
статистик мэдээлэл авах ezStat
аппликейшн.



Монстат

Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг
унших Монстат аппликейшн.



Mass mail

www.nso.mn сайтад бүртгүүлснээр
цахим шуудангаар тогтмол авч болно.



Social Network



www.facebook.com/pages/Статистик-Мэдээлэл



www.twitter.com/statistic_mn



ЛАВЛАХ УТАС

1900-1212

1 мин = 200 төгрөг



ХАЯГ:

Аймгийн ЗДТГ-ын №108, 116 тоот өрөө
Утас: 7048-4278, 7048-3442
И-мэйл: Stat_Altai@yahoo.com

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж(статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон иргэнийг ажиллагчдад хамруулна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно. Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Гадаад худалдаа

Гаалийн хорооны статистикт үндэслэн гадаад худалдааны салбарын үндсэн үзүүлэлтийг тооцож байна. дэлхийн худалдааны байгууллагаас зөвлөмж болгосон “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг тогтоодог.

Барааны экспорт гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс эргэн оруулах үүрэггүйгээр барааг гадаадад гаргахыг ойлгоно.

Барааны экспортод эх орны үйлдвэрлэлийн барааг гадаадад гаргах, мөн реэкспортыг оруулна. Эх орны үйлдвэрлэлийн бараанд мөн түүнчлэн улс оронд оруулсан, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.

Барааны реэкспортод Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт урьд нь оруулсан боловч ямар нэгэн дахин боловсруулалт хийгдээгүй, гаалийн татвар, хураамж болон төлбөргүй, эдийн засгийн хориг хязгаарлалтгүйгээр гадаадад гаргасан барааг оруулна.

Барааны импорт гэж эргүүлж гаргах үүрэггүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт гадаадаас бараа оруулахыг ойлгоно.

Импортод улс орны эдийн засгийн хэрэглээнд зориулж гадаадаас оруулсан бараа, мөн реимпортлох барааг хамруулна. Реимпортын бараанд Монгол Улсын нэтаг дэвсгэрээс урьд нь гаргасан хэдий ч эргүүлэн оруулсан барааг оруулна.

Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны барааны нийт эргэлтыг тодорхойлно.

Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

$$\frac{I_{ct}^L}{P_{io}Q_{io}} = \frac{P_{it}Q_{it}}{P_{io}Q_{io}}$$

I_{ct}^L -т тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

P_{it} -'и' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'и' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'и' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,
-нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг. Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Тээвэр

Тээврийн орлого нь ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаанаас орсон орлого юм.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол улсын эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг,
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг,
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг,
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг,
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг,
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг,
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг,
- Бусад гэмт хэрэг,

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ноогдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээх тооцно. Үүнд:

- ❖ Уг этгээдийг гэмт хэргийн гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан,
- ❖ Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан,
- ❖ Уг эдгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон,
- ❖ Уг итгээд хэргээ илчлэн ирсэн,
- ❖ Гэмт хэрэгт сөрдөгдөх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2019 оны 09 дүгээр сарын байдал)

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 9 дугаар сарын эцэст 696 байгаа нь өмнөх оны мөн үеэс 178 (20.4%) хүнээр буурч, өмнөх сараас 221 (24.1%) хүнээр буурч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 353 (50.7%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 3 (0.4%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба 2 (66.7%) эмэгтэйчүүд байна.

2019 оны 9 дугаар сард ажилгүй 133 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 31 иргэн ажилд зуулчлагдан орж, 354 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг сургууль төгссөн иргэд 24.8 хувь нь, хамгийн бага хувийг цэргээс халагдсан иргэд буюу 0.8 хувь нь эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 48.1 хувийг бүрэн дунд, 29.6 хувийг дипломын болон бакалаврын дээд, 10.9 хувийг техник мэргэжлийн, 3.7 хувийг суурь, 4.3 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.4 хувийг бага, 1.0 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.


Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 58.3 хувийг 15-34 насны залуучууд, 37.7 хувийг 35-54 насныхан, 4.0 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.

Хөдөлмөр, Халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй иргэд жил бүрийн 9 сарын байдлаар



2015 I-IX 2016 I-IX 2017 I-IX 2018 I-IX 2019 I-IX

Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2019 оны эхний 9 сарын байдлаар




Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр 2019 оны 9 сарын эцэст



ЭРҮҮЛ МЭНД


Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 9 сарын байдлаар 1035 эх амаржиж, 1049 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 62 (6.4%)-аар, амьд төрсөн хүүхэд 64 (6.5%)-аар тус тус нэмэгдсэн байна.




Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2019 оны эхний 9 сард 20 болж, өмнөх оны мөн үеэс 4 (25%)-аар нэмэгдэж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 болж, өмнөх оны мөн үетэй ижил байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 284 болж, өмнөх оны мөн үеэс 97 (25.5%)-аар буурахад гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 72 (84.7%)-аар, хачигт реккетиоз өвчнөөр өвчлөгчид 12 (34.3%)-аар, салхинцэцэг өвчнөөр өвчлөгчид 19 (18.8%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид 21 (110.5%), сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 11 (84.6%) өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Халдварт өвчний төрлөөр 2019 оны 9 сарын байдлаар




БОЛОВСРОЛ

Ерөнхий боловсролын 29 сургууль, 28 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад 11.7 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.3 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1267 хүүхэд, арван хоёр дугаар ангид 595 хүүхэд тус тус элсэн суралцаж байна.


Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид, жил бүрийн хичээлийн жилд




Ерөнхий боловсролын сургуулийн багш, жил бүрийн хичээлийн жилд



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхдүүд, жил бүрийн хичээлийн жилд




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн багш, жил бүрийн хичээлийн жилд



ТӨСВИЙН ОРЛОГО

Орон нутгийн төсөвт нийт 48.9 тэрбум төгрөг бүрдэж, төлөвлөгөө 87.7 хувиар, үүнээс улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 10.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 85.4 хувиар, тусгай зориулалтын шилжүүлэг 27.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 85.5 хувиар, орон нутгийн хөгжлийн сан 5.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 81.5 хувиар, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 6.0 тэрбум төгрөгт хүрч 113.7 хувиар, татварын орлого 5.1 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 104.7 хувиар, татварын бус орлого 798.1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 1.9 дахин их биелүүлсэн байна. Аймгийн төсөвт байгууллагууд 2.4 сая төгрөгийн авлагатай, 371.8 сая төгрөгийн өглөгтэй байна.


ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, мянган төгрөгөөр 2019 оны IX сард



ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн гүйцтгэл 43.7 тэрбум төгрөгт хүрч 81.1 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 94.3, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 94.6, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 86.7, хангамж, бараа материалын зардал 83.8, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал 62.4, нормативт зардал 80.2, эд хогшил, урсгал засварын зардал 79.1, томилолт, зочны зардлын 74.5, хөрөнгийн зардлын 63.7 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.


ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА ХУВИАР




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний 9 дүгээр сард 11.9 тэрбум төгрөгт хүрчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 90 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл, 4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 6 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 12.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт /сая төгрөг/



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 2019 оны 9-р сарын байдлаар, хувиар



БАНК

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2019 оны дүгээр сарын эцэст 107.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 13.1 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар өсчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт	Хугацаа	
	2018-IX	2019-IX
Мөнгөний нийлүүлэлт M2	94384.7	107531.1
Сарын өөрчлөлт, хувиар	25.5	13.9
Нийт хадгаламж	80359.1	90242.0
Сарын өөрчлөлт, хувиар	24.8	12.3
Төгрөгийн хадгаламж	80136.4	90079.2
Сарын өөрчлөлт, хувиар	24.9	12.4
Валютын хадгаламж	222.7	162.8
Сарын өөрчлөлт, хувиар	-5.3	-26.9

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 0.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 0.4 тэрбум төгрөг буюу 45.5 хувиар буурсан байна.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9 дүгээр сарын эцэст 127.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 15.4 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9 дүгээр сарын эцэст 895.3 сая төгрөг болж, өмнөх оноос 356.1 сая төгрөг буюу 66.1 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл 2019 оны 9 дүгээр сарын эцэст тэрбум 140.0 сая төгрөг болж өмнөх оноос 178.4 сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.9 хувийг эзэлж байна.

Үнэ


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2019 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6.1 хувь, өмнөх оны жилийн эцсээс 4.7 хувиар өсч, өмнөх сараас 0.4 хувиар буурсан байна. Ерөнхий индекс 2019 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.4 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 2.0 хувь, тээврийн бүлгийн индекс 1.3 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019-09	2019-09	2019-09
		2018-09	2018-12	2019-08
Ерөнхий индекс	100.0	106.1	104.7	99.6
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	111.8	110.2	98.0
Согтууруулах ундаа, тамхи	3.2	100.3	100.0	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	101.8	101.0	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	108.2	106.4	100.9
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	107.4	106.6	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	104.3	103.7	101.3
Тээвэр	12.2	102.3	98.5	98.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	98.8	98.8	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.8	100.8	99.0
Боловсролын үйлчилгээ	4.7	112.7	112.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	107.8	107.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	105.6	102.3	100.2

Ерөнхий индекс 2019 оны 9 дүгээр сард жилийн эцсээс 4.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 10.2 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн индекс 12.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн индекс 7.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ЦАХИЛГААН ХОЛБОО


Суурин телефон цэгийн тоо 550, холбоо ашиглалтын орлого 224.5 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 158.2 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгээр 16 суудалтай ажиллаж, интернетээр дунджаар 0.8 мянган хүнд үйлчилжээ.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого сая төгрөгөөр



■ 2018 оны IX сард ■ 2019 оны IX* сард

Суурин утасны цэгийн тоо




■ 2018 оны IX сард ■ 2019 оны IX* сард

ХӨДӨӨ АЖ АХУЙ


Аймгийн хэмжээнд 2019 оны 9 дугаар сарын байдлаар төллөх насны 1570.8 мянган хээлтэгч малын 1128.8 мянга буюу 71.8 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 69.3 хувь, эм хонины 79.2 хувь, ингэний 44.2 хувь, үнээний 62.5 хувь, гүүний 61.3 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 96.8 хувь буюу 1094.4 мянган төл бойжиж байна.

Том малын зүй бусын хорогдол 2019 оны 9 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 37996 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 90.3 мянга буюу 3.5 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 1564, үхэр 1780, тэмээ 63, хонь 11168, ямаа 23421 байна. Нийт хорогдлын 29.4 хувийг хонь, 61.6 хувийг ямаа эзэлж байна.


Бойжсон төл, 2019 оны 9-р сарын байдлаар




Төллөсөн хээлтэгч, 2019 оны 9-р сарын байдлаар



Хорогдсон төл, 2019 оны 9-р сарын байдлаар, сумаар






ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2019 оны 9 дүгээр сард аймгийн төв буюу Есөнбулаг суманд ноолуур 55.0 мянган төгрөг, хонины арьс 3000 төгрөг, ямааны ноолуургүй арьс 3500 төгрөг байна.

ГАЗАР ТАРИАЛАН

Энэ сарын байдлаар үр тариа 496.6 тн, төмс 441.8 тн, хүнсний ногоо 407.6 тн, малын тэжээлийн ургамал 1154.8 тонныг тус тус хурааж аваад байна. Мөн 1555.8 тн байгалийн хадлан, 21.3 тн гар тэжээл, 591.9 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

Хураасан ургац, бэлтгэсэн өвс хадлан, жил бүрийн 9 сарын байдлаар



Онцгой байдлын газар: Гуравдугаар улирлын байдлаар 53 удаагийн гал түймэр гарчээ. Тус газраас 6610 айл өрх, 169 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, 255.0 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварсан байна. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан гал түймрийн улмаас 248.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Нийт 3 удаагийн гал түймэр гарсны 21 галыг газар дээр нь унтрааж, өөрөө унтарсан гал түймэр 6, иргэд 26 гал түймрийг өөрсдөө унтраасан байна.

Галын мэдээ



Гамшгийн нийт 28 дуудлага ирж, 9 дуудлагад шуурхай бүлэг ажилласан байна. Үүнд цаг агаарын аюулт үзэгдэл 8, химийн хорт бодис алдагдсан 1 дуудлага ирсэн байна.

Есөнбулаг сумын Рашаант багийн “Бага шанд” гэдэг газар бөгөөд аймгийн төвийн оршин суугчдад чичирхийлэл мэдрэгдсэн. Тухайн бүс нутагт айл өрх, барилга байшин үгүй, одоогоор учирсан хохирол байхгүй.


Тонхил сумын Зүйл багийн “Баянбулагийн эх” гэдэг газар сумын төвөөс хойд зүгт 24 км-т /Ө-46°53'00", У-93°87'00"/ 2019.03.02-ны өдрийн 03:46 цагт 3.8 магнитутын хүчтэй газар хөдлөлт болсон учирсан хохирол байхгүй.

ГЭМТ ХЭРЭГ

Байгууллага, иргэдийн 528.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 195 гэмт хэрэг гарч, 156 (80.0%) хөнгөн, 39 (20.0%) хүнд гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Эдгээр хэргүүдээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт, хулгай, залилах, хүрээлэн байгаа орчны эсрэг хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, өмчлөх эрхийн эсрэг хэргүүд 82.1 хувийг, бусад хэргүүд 17.9 хувийг эзлэж байна.


Нийт хэргийн 52.2 хувь нь Есөнбулаг сум буюу аймгийн төвд гарсан хэрэг эзэлж байна. Хүнд гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 2 (5.4%), хөнгөн гэмт хэргийн тоо 48 (44.4%) малын хулгай 11 (2.4 дахин), хүрээлэн байгаа орчны эсрэг хэрэг 5 (5 дахин), өмчлөх эрхийн гэмт хэрэг 17 (21.2%)-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг жил бүрийн 3-р улиралд




Говь-Алтай аймгийн 2019 оны IX-XI сарын цаг агаарын урьдчилсан төлөв


Есдүгээр сард. Олон жилийн дунджаар агаарын температурын сарын дундаж нь Говь-Алтайн зүүн өмнөд хэсгээр 14-19 градус, Говь-Алтайн баруун болон хойд нутгаар 4-9 градус, бусад нутгаар 9-14 градус дулаан байдаг. ([Зураг-1](#))




Энэ сард олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй байна. ([Зураг-2](#))




Олон жилийн дунджаар хур тунадас Говь-Алтайн ихэнх нутгаар 4-16 мм, бусад нутгаар 17-30 мм ордог. ([Зураг-3](#))



Энэ сард олон жилийн дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна. ([Зураг-4](#))



Аравдугаар сард. Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь Говь-Алтайн зүүн өмнөд нутгаар 4-8 градус дулаан, бусад нутгаар 2 градус хүйтнээс 4 градус дулаан байдаг. ([Зураг-5](#))



Энэ сард олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй байна. Уур амьсгалын дунджаар хур тунадас Говь-Алтайн ихэнх нутгаар 4-16 мм, бусад нутгаар 17-30 мм ордог. Энэ сард олон жилийн дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна.

Арваннэгдүгээр сард. Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь Говь-Алтайн өмнөд хэсгээр 8 градус хүйтнээс 2 градус хүйтэн, бусад нутгаар 8-13 градус хүйтэн байдаг. Энэ сард агаарын температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй байна. Уур амьсгалын дунджаар хур тунадас 0-10 мм ордог. Энэ сард хур тунадас ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй байна.

Эх үүсвэр: Говь-Алтай УЦУОШТ-ийн УМХ Утас: 70483093

**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшинээр	By educational level	2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	9-сар	
						In September 2018	2019
Бүгд	Total	1044	786	796	919	874	696
Үүнээс: эмэгтэй	of which:female	547	435	430	462	479	353
Дээд боловсролтой	Higher education	252	265	280	226	314	206
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	72	35	49	46	38	30
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	81	70	66	72	70	76
Бүрэн дунд	Upper secondary school	483	341	331	475	384	334
Суурь	Compulsory secondary school	112	42	41	59	48	26
Бага	Primary school	35	28	27	23	14	17
Боловсролгүй	Uneducated persons	9	5	2	18	6	7

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2019 оны 9 сарын эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of september 2019**

Сар Month s	Бүгд Total	Үүнээс : эмэгтэй female	Үүнээс: насны бүлгээр of which:by age group											
			15-24	Эмэгтэй female	25-34	Эмэгтэй female	35-44	Эмэгтэй female	45-59	Эмэгтэй female	55-59	Эмэгтэй female	60+	Эмэгтэй female
I														
II	879	430	183	93	290	145	230	119	147	63	20	6	9	4
III	811	395	184	98	267	126	197	103	135	59	21	7	7	2
IV	897	452	198	108	302	156	215	106	148	70	26	9	8	3
V	831	435	186	106	279	149	203	105	132	62	23	10	8	3
VI	515	287	133	77	161	96	117	63	87	46	13	5	4	0
VII	892	471	224	121	296	170	208	110	128	62	26	6	10	2
VIII	917	470	236	120	303	168	210	114	123	59	34	6	11	3
IX	696	353	187	99	232	130	154	79	87	38	28	3	8	4

**2019 ОНЫ 9 САРД АЖИЛГҮЙЧҮҮДЭЭС ТАЙЛАНТ САРД АЖИЛД ОРСОН ХҮН
NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 9 months of 2019**

Сар Month	Бүгд Total	Төрийн өмчит үйлдвэрийн газарт	Төрийн төсөвт байгууллагад Government organization	Компани Company	Хоршоо Cooperative	Бусад Other
I						
II	7		5			2
III	40		29	2		9
IV	33	1	12	18		2
V	28		15	8		5
VI	147		120	27		0
VII	79		47	32		0
VIII	39		4	34		1
IX	31		1	27		3

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР
NUMBER OF UNEMPLOYED, by som**

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	9-р сар		
						September		
						2018	2019	2019%
Есөнбулаг	Yesunbulag	284	326	353	487	413	372	90.1
Алтай	Altai	40	10	27	17	18	17	94.4
Баян-Уул	Bayan-Uul	22	40	28	30	41	20	48.8
Бигэр	Biger	56	35	24	29	19	19	100.0
Бугат	Bugat	26	19	31	30	23	10	43.5
Дарив	Darib	47	17	12	54	21	36	171.4
Дэлгэр	Delger	45	44	75	24	30	23	76.7
Жаргалан	Jargalan	33	11	6	11	17	8	47.1
Тайшир	Taishir	17	15	16	3	16	13	81.3
Тонхил	Tonhil	68	20	11	30	26	23	88.5
Төгрөг	Tugrug	37	21	16	21	16	14	87.5
Халиун	Haliun	35	25	30	25	34	10	29.4
Хөхморьт	Huhmorit	15	34	16	12	16	17	106.3
Цогт	Tsogt	73	61	63	38	50	33	66.0
Цээл	Tseel	37	15	16	33	49	27	55.1
Чандмана	Chandmana	75	34	45	42	39	36	92.3
Шарга	Sharga	46	34	12	18	21	8	38.1
Эрдэнэ	Erdene	25	25	15	15	25	10	40.0
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	63	-	-				
ДҮН	TOTAL	1044	786	796	919	874	696	79.6

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан, даатгалын төрлөөр
 REVENUE OF SOCIAL INSURANCE FUND AND INSURERS, by types of funds and insurance

Үзүүлэлт	Indicators	Сая төгрөг / Mln tugrug	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид / Pensionaries, who got pension from the social insurance fund
Нийгмийн даатгалын сангийн орлого	Revenue of social insurance fund	13019.69	9295
Тэтгэврийн даатгалын сангийн	Retirement insurance fund	8495.5	7849
Тэтгэмжийн даатгалын сангийн	Benefit insurance fund	956.74	1275
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Health insurance fund	2578.38	0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	IAOD insurance fund	784.7	32
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Unemployment insurance fund	204.37	139
Нийгмийн даатгалд даатгуулагчид / The number of insurers			
Заавал даатгуулагчид / Compulsory insurers			8884
Сайн дураар даатгуулагчид / Voluntary insurers			3391
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид / Health insurance insurers			36923

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
PUBLIC HEALTH OF POPULATION

№	Сумын нэр	Soum	Төрсөн эх <i>Women who gave births</i>		Эхийн эндэгдэл <i>Maternal Deaths</i>		Төрсөн хүүхэд <i>Births</i>		Нялхасын эндэгдэл <i>Infant mortality</i>		1-5 хүртэлх настай хүүхдийн эндэгдэл <i>Under-five mortality</i>		Нийт нас баралт <i>Deaths</i>		Эмнэлэгт нас баралт <i>Deaths</i>	
			2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	902	959			914	973	11	13		1	79	99	17	23
2	Алтай	<i>Altai</i>	4	5			4	5	0	0		1	4	5	2	0
3	Баян-Уул	<i>Bayan-Uul</i>	6	4			6	4	0	0		1	15	13	3	3
3	Бигэр	<i>Biger</i>	4	8			4	8	0	0	1	0	6	5		
4	Бугат	<i>Bugat</i>	3	5			3	5	0	1		0	4	10	4	3
5	Гуулин	<i>Gulin</i>	1				1		0	0		0	6	1		
5	Дарив	<i>Darib</i>	6	4			5	4	1	1		0	10	4	4	
6	Дэлгэр	<i>Delger</i>	3	4			3	4	0	0		1	8	6		3
7	Жаргалан	<i>Jargalan</i>							1	0		0	5	5	1	2
8	Тайшир	<i>Taishir</i>							1	0		0	5	8	1	
8	Тонхил	<i>Tonhil</i>	8	11			8	11	0	1	1	0	15	9	4	2
9	Төгрөг	<i>Tugrug</i>	5	7			5	7	0	2	1	0	8	8	2	5
10	Халиун	<i>Haliun</i>	2	2			3	2	0	0		0	10	4	2	1
10	Хөхморьт	<i>Huhmorit</i>	2	4			2	6	0	1		0	11	11	4	4
11	Цогт	<i>Tsogt</i>	7	6			6	5	1	1	1	0	10	9	3	2
12	Цээл	<i>Tseel</i>	5	2			6	2	0	0		0	8	7	1	
12	Чандмана	<i>Chandmani</i>	6	6			6	6	1	0		0	6	11	2	
13	Шарга	<i>Sharga</i>	1				1		0	0		0	2	6		1
14	Эрдэнэ	<i>Erdene</i>	7	6			7	5		0		0	2	8		1
15	Баянтоорой	<i>Bayantoroi</i>	1	2			1	2	0	0		0	7	3	3	1
22	Дүн	Total	973	1035	0	0	985	1049	16	20	4	4	221	232	53	51

№	Сумын нэр	Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд <i>Infectious Diseases</i>		Үүнээс: Of which:													
					БЗХӨ STID						Гепатит <i>Hepatite</i>		Сүрьеэ <i>Tuberculosis</i>		Улаан бурхан		Бусад <i>Other</i>	
			Трихоминаз <i>Trichomoniasis</i>		Тэмбүү <i>Syphilis</i>		Заг хүйтэн <i>Gonorrhea</i>											
			2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	248	137	11	6	35	31	10	27	1		9	9			182	64
2	Алтай	<i>Altai</i>	4	3			4			2							0	1
3	Баян-Уул	<i>Bayan-Uul</i>	7	14			4	2					1	1			2	11
3	Бигэр	<i>Biger</i>	7	0			3		1				1				2	0
4	Бугат	<i>Bugat</i>	17	10			8				1						8	10
5	Гуулин	<i>Gulin</i>	1	1								1					1	0
5	Дарив	<i>Darib</i>	1	7	1	1	0	1						3			0	2
6	Дэлгэр	<i>Delger</i>	15	6			5	2	2	1	1		1				6	3
7	Жаргалан	<i>Jargalan</i>	2	4			1	2		1				1			1	0
8	Тайшир	<i>Taishir</i>	5	8		1	1	2		1				1			4	3
8	Тонхил	<i>Tonhil</i>	4	5			1	2					2				3	1
9	Төгрөг	<i>Tugrug</i>	11	4	1	1	9	2									1	1
10	Халиун	<i>Haliun</i>	11	13			4	5						4			7	4
10	Хөхморьт	<i>Huhmorit</i>	10	7	1		5	3	1	2			1	1			2	1
11	Цогт	<i>Tsogt</i>	8	16	3			4	2	1							3	11
12	Цээл	<i>Tseel</i>	7	3	1	1	4	2									2	0
12	Чандмана	<i>Chandmani</i>	3	6			1	4		1				1			2	0
13	Шарга	<i>Sharga</i>	4	9			1	2	1	2		1		1			2	3
14	Эрдэнэ	<i>Erdene</i>	0	7				1.0		1							0	5
15	Баянтоорой	<i>Bayantoroi</i>	0	15				1									0	14
16	Харьяаллын бус		16	9	3	1	10	7	2	1.0							1	0
22	Дүн	Total	381	284	21	11	96	73	19	40	3	2	13	24	0	0	229	134

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

мян.мөг thous.tug

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
НИЙТ ОРЛОГО		55,807,916.7	48,957,029.7	87.7
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН				
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ				
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ		11,705,934.1	10,001,879.8	85.4
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН		32,562,125.4	27,848,863.9	85.5
ШИЛЖЭЭГҮЙ ҮЛДЭГДЭЛ		6,253,500.0	5,096,436.8	81.5
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		-	-	-
1. ТАТВАРЫН ОРЛОГО				
1.1 Орлогын албан татвар				
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар				
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилгах хөдөлмөр эрхлэлтийн орлого				
Үйл ажиллагааны орлого		3,150,859.8	3,411,898.2	108.3
Хөрөнгийн орлого		205,620.7	105,882.2	51.5
Хөрөнгө борлуулсны орлого		710,425.5	769,608.3	108.3
Шууд бус орлого		52,470.0	32,114.8	61.2
Шууд бус орлого		69,041.7	85,556.8	123.9
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт				
		(550,000.0)	(449,963.1)	81.8
1.2 Хөрөнгийн албан татвар				
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар				
Галт зэвсгийн албан татвар		232,255.3	148,636.7	64.0
татвар		35,083.0	17,536.0	50.0
Малд ногдуулах албан татвар		254,260.0	292,880.8	115.2
		-	-	0.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж				
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж				
Улсын тэмдэгтийн хураамж		694,300.6	666,717.5	96.0
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт		234,420.7	224,741.7	95.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		113,255.7	132,502.1	117.0
Хог хаягдлын хураамжийн төлбөр		(5,000.0)	(2,461.2)	49.2
1.3.2 Газрын төлбөр		9,379.0	3,067.6	32.7
Үүнээс: Газрын төлбөр		116,786.0	91,633.2	78.5
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		340,649.9	191,703.9	56.3
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр		-	-	0.0
Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр		-	163.2	0.0
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр		28,217.0	131,531.5	466.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		90,675.0	66,885.9	73.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр		-	-	0.0
1.3.4 Бусад татвар				
		338.0	51,691.3	0.0
2. Татварын бус орлого				
Хүү, торгуулийн орлого				
Төсвийн байгууллагын өөрийн орлого		417,040.6	798,019.8	191.4
Түрээсийн орлого		362,167.0	751,049.3	207.4
Бусад орлого		17,597.8	16,804.2	95.5
3. Хөрөнгийн орлого				
Өмч хувьчлалын орлого		37,275.8	30,166.3	80.9
		15,000.0	130,961.2	873.1
УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО				
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		980,900.0	1,410,879.4	143.8
НӨАТатвар		87,150.0	185,692.4	213.1
Онцгой албан татвар		805,000.0	1,161,681.0	144.3
Агаарын бохирдлын төлбөр		30,700.0	28,865.8	94.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		21,550.0	18,928.1	87.8
		36500.0	15712.1	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE soum

мян.төг thous.tug

№	Сум	Soum	Нийт орлого	Gross income	
			Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	640,900.0	696,791.4	97.6
2	Алтай	Altai	26,412.0	35,941.9	104.6
3	Баян-Уул	Bayn-Uul	46,628.5	34,571.9	123.1
4	Бигэр	Biger	26,837.0	31,856.4	156.5
5	Бугат	Bugat	32,956.0	38,668.6	142.3
6	Дарив	Dariv	26,625.0	32,706.7	113.6
7	Дэлгэр	Delger	30,800.0	35,160.8	130.6
8	Жаргалан	Jargalan	25,639.4	31,207.7	143.7
9	Тайшир	Taishir	15,184.5	46,071.6	116.3
10	Тонхил	Tonhil	74,636.0	99,396.3	150.0
11	Төгрөг	Tugrug	33,739.4	42,878.0	114.9
12	Халиун	Khaliun	17,177.3	18,374.1	133.2
13	Хөхморьт	Khukhmorit	21,250.0	23,721.1	111.3
14	Цогт	Tsogt	34,278.0	40,303.7	106.5
15	Цээл	Tseel	42,421.0	50,258.5	117.5
16	Чандмань	Chandmani	33,846.0	48,804.3	123.6
17	Шарга	Sharga	21,190.0	23,466.6	129.6
18	Эрдэнэ	Erdene	24,178.7	28,767.2	182.0
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	11,025.0	10,917.7	143.7
20	Гуулин тосгон	Guulin	12,245.4	13,111.1	182.0
21	Татварын хэлтэс	Straight communicant	4,088,388.0	4,626,873.6	111.6
	Дүн		5,286,357.2	6,009,849.2	112.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

/мян.мөг, thous.tug/

Төрөл type	Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,878,288.3	43,669,125.0	81.1
НИЙТ ЗАРЛАГА	52,515,108.3	43,587,763.5	83.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,446,596.9	39,082,096.5	86.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,737,557.1	35,324,687.0	91.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,898,169.7	23,482,377.9	94.3
Үндсэн цалин	20,179,965.2	19,538,755.5	96.8
Нэмэгдэл	1,300,100.5	937,271.4	72.1
Унаа хоолны хөнгөлөлт	145,855.4	128,789.8	88.3
Урамшуулал	1,844,172.8	1,554,553.7	84.3
Гэрээт ажлын хөлс	1,428,075.8	1,323,007.6	92.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,131,646.9	2,963,869.7	94.6
Тэтгэврийн даатгал	2,113,349.6	2,031,472.4	96.1
Тэтгэмжийн даатгал	248,245.6	230,462.7	92.8
ҮОМШӨ-ний даатгал	198,598.8	182,715.3	92.0
Ажилгүйдлийн даатгал	74,966.0	63,583.0	84.8
Эрүүл мэндийн даатгал	496,486.9	455,636.4	91.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,630,285.7	3,146,688.2	86.7
Гэрэл, цахилгаан	297,916.5	241,852.1	81.2
Түлш, халаалт	3,218,353.9	2,814,334.4	87.4
Цэвэр, бохир ус	114,015.3	90,501.7	0.0
Байрны түрээс	1,086,111.7	909,876.0	83.8
Хангамж, бараа материалын зардал	1,086,111.7	909,876.0	83.8
Бичиг хэрэг	109,289.2	93,174.6	85.3
Тээвэр, шатахуун	681,178.7	603,040.3	88.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,271.1	72,039.7	74.1
Ном, хэвлэл	46,483.2	28,947.3	62.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,732.7	19,811.2	62.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	120,156.8	92,863.0	77.3
Нормативт зардал	1,345,018.7	1,078,570.4	80.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	255,561.3	194,273.3	76.0
Хоол, хүнс	1,018,229.3	853,910.8	83.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	71,228.1	30,386.3	42.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,115,419.5	882,561.8	79.1
Багаж, техник, хэрэгсэл	267,012.6	223,297.0	83.6
Тавилга	88,712.1	43,282.9	48.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,275.0	2,505.8	47.5
Урсгал засвар	754,419.8	613,476.2	81.3
Томилолт, зочны зардал	345,395.9	257,171.1	74.5
Гадаад албан томилолт	0.0	880.0	#DIV/0!
Дотоод албан томилолт	345,395.9	256,291.1	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,			
хураамж	2,182,003.7	1,744,834.9	80.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил			
үйлчилгээний төлбөр хураамж	1,962,140.0	1,556,634.1	79.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,265.5	53,654.0	89.0
Даатгалын үйлчилгээ	21,319.0	17,674.3	82.9
Тээврийн хэрэгслийн татвар	6,563.6	4,120.1	62.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,028.6	1,125.7	37.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	109,813.1	100,957.5	91.9
Газрын төлбөр	3,532.4	967.9	27.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,441.5	3,757.8	69.1

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

Үргэлжлэл
мян.төг, tous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,900.0	5,943.4	60.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,003,505.3	858,737.0	85.6
Бараа үйлчилгээний бусад зардал	868,725.4	765,953.8	88.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	134,779.9	92,783.2	68.8
ТАТААС	15,000.3	15,000.3	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	15,000.3	15,000.3	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,694,039.5	3,742,409.2	55.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,128,546.6	3,314,128.5	54.1
Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,128,546.6	3,314,128.5	54.1
Бусад урсгал шилжүүлэг	565,492.9	428,280.7	75.7
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	96,800.0	58,550.0	60.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	286,411.9	260,007.3	90.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,568.6	11,046.9	35.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ал	0.0	0.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,712.4	98,676.5	65.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,068,511.4	4,505,667.0	63.7
Бусад хөрөнгө	7,068,511.4	4,505,667.0	63.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,363,180.0	81,361.5	6.0
Эргэж төлөгдөх зээл	1,363,180.0	81,361.5	6.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,409,418.6	4,892,193.6	-203.0
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,409,418.6	-4,892,193.6	-203.0
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,409,418.6	-4,892,193.6	-203.0
Өмч хувьчлал	0.0	0.0	0.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	7,028,733.7	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар

PERFORMANCE REVENUE *soum*

мян.төг, thous.tug

№	Сум	Soum	Орон нутаг Provincial government		
			Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	9654186.4	8978812.3	93.0
2	Алтай	<i>Altai</i>	1688373.0	1546252.9	91.6
3	Баян-Уул	<i>Bayn-Uul</i>	1367945.4	1235807.8	90.3
4	Бигэр	<i>Biger</i>	1227066.6	1169741.8	95.3
5	Бугат	<i>Bugat</i>	1557146.3	1346459.0	86.5
6	Дарив	<i>Dariv</i>	1416693.5	1221597.6	86.2
7	Дэлгэр	<i>Delger</i>	1556651.7	1341418.3	86.2
8	Жаргалан	<i>Jargalan</i>	1279902.2	1035114.0	80.9
9	Тайшир	<i>Taishir</i>	1289941.0	1101102.7	85.4
10	Тонхил	<i>Tonhil</i>	1665000.0	1286599.9	77.3
11	Төгрөг	<i>Tugrug</i>	1266342.4	1098787.7	86.8
12	Халиун	<i>Khaliun</i>	1495079.2	1279097.5	85.6
13	Хөхморьт	<i>Khukhmorit</i>	1457554.1	1344374.5	92.2
14	Цогт	<i>Tsogt</i>	1683452.1	1427801.7	84.8
15	Цээл	<i>Tseel</i>	1518217.9	1185066.7	78.1
16	Чандмань	<i>Chandmani</i>	1474931.2	1308761.5	88.7
17	Шарга	<i>Sharga</i>	1305254.6	1127571.4	86.4
18	Эрдэнэ	<i>Erdene</i>	2007320.5	1523624.2	75.9
19	Гуулин тосгон	<i>Guulin</i>	860789.1	735444.5	85.4
20	Баянтоорой тосгон	<i>Bayntooroi</i>	902993.0	808256.0	89.5
21	Говь-Алтай аймаг шууд харилцагч	<i>Straight communicant</i>	17203448.1	11567432.8	67.2
	Дүн		53878288.3	43669125.0	81.1

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН салбараар, (оны үнээр, мян.төг)
GROSS INDUSTRIAL OUTPUT, sector at current price thous.tug

Салбараар	2018 IX	2018 I-IX	2019 IX*	2019 I-IX*	<u>2019 I-IX*</u> 2018 I-IX
A	1	2	3	4	5
Нийт дүн	1379140.7	5425372.2	1248853.1	11999369.8	221.2
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	73450.0	792289.5	0.0	703560.3	88.8
Нүүрс олборлолт	73450.0	792289.5	0.0	703560.3	88.8
Төмрийн хүдэр олборлолт	186745.0	930639.3	68608.6	671970.1	0.0
Боловсруулах аж үйлдвэр	33551.2	620129.2	38929.7	468027.5	75.5
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	1143.0	13377.0	910.6	21250.1	158.9
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	12000.0	0.0	45750.0	0.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	8756.2	318659.0	13729.5	167823.5	52.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	23652.0	276093.2	24289.6	233203.9	84.5
Ундаа үйлдвэрлэл	2677.8	16606.3	2443.9	26733.6	161.0
Нэхмэлийн үйлдвэрлэл	7335.0	26381.0	1175.0	21140.0	0.0
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2599.0	7016.0	0.0	2695.0	38.4
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	535.0	3749.9	300.0	4256.0	113.5
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	6065.0	31343.0	7110.0	35874.0	114.5
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	133982.0	216813.4	17600.0	101144.0	0.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	0.0	1885.5	0.0	4840.0	0.0
